

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

АГУУЛГА

Бүлэг 1	Нийтлэг үндэслэл
Бүлэг 2	Бүртгэлийн үйл явц
Бүлэг 3	Бүртгэлийн арга хэлбэр
Бүлэг 4	Бүртгэлийн шалгуур, нөхцөл
4.1	Анх үнэт цаас бүртгүүлэх үеийн шалгуур
4.1.1	Үнэт цаас гаргагчид тавих шалгуур
4.1.2	Үнэт цаасанд тавих шалгуур
4.2	Бүртгэлтэй байх хугацааны шалгуур
Бүлэг 5	Тогтмол биелүүлэх үүрэг
5.1	Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг
5.2	Мэдээлэл ил тод болгох
Бүлэг 6	Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг бүртгэх
Бүлэг 7	Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах
7.1	Туслах захаас үндсэн захруу шилжих
7.2	Үндсэн захаас туслах захруу шилжих
Бүлэг 8	Үнэт цаасны бүртгэлийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах
Бүлэг 9	Хураамж
Бүлэг 10	Хариуцлага
Бүлэг 11	Бусад асуудал
<i>Хавсралт 1</i>	<i>Бүрдүүлэх материалын жагсаалт</i>
<i>Маягт 1-4</i>	<i>Өргөдөл болон мэдүүлгийн маягтууд</i>
<i>Хавсралт 2</i>	<i>Хураамж</i>
<i>Хавсралт 3</i>	<i>Үнэт цаас гаргагчдын мэдээлэл түгээх заавар</i>

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү журам нь Монгол улсын үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэт цаасаа олон нийтэд санал болгох этгээдийн хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /цаашид МХБ гэх/-д бүртгэх, бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, үнэт цаасны бүртгэлийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх ерөнхий харилцааг зохицуулна.
2. Энэхүү журам нь МХБ-ийн үнэт цаасны зах зээлийн харилцаанд оролцож буй гадаад, дотоодын үнэт цаас гаргагчдад нэгэн адил үйлчилнэ.
3. Хувьцаанаас бусад төрлийн үнэт цаас /өрийн хэрэгсэл, үүсмэл үнэт цаас гэх мэт/-ны бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдох харилцаа нь нэмэлт болон тусгай журмуудаар зохицуулагдана.
4. Уул уурхай, эрдэс баялагийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчид төдийгүй онцгойлсон салбар, чиглэлийн үнэт цаас гаргагчдыг бүртгэх нэмэлт журам гаргаж болно.
5. Энэхүү журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид СЗХ гэх/, МХБ-ээс гаргасан холбогдох дүрэм журам, эрх зүйн актуудаас бүрдэнэ.
6. Энэхүү журмыг хэрэгжүүлэгч нь МХБ байх ба үнэт цаас гаргагч болон үнэт цаас бүртгүүлэхээр өргөдөл ирүүлсэн аливаа хуулийн этгээд нь энэхүү журмыг дагаж мөрдөнө.
7. МХБ нь энэхүү журмын зохицуулалтыг тодруулах зорилгоор зөвлөмж, зааварчилгаа гаргаж болох ба энэ нь журмын адил хүчин төгөлдөр байна..
8. МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах, тэдгээрийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацааг тогтоох ба журмын хавсралтад Гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.
9. МХБ нь үнэт цаас гаргагч болон түүний үнэт цаасыг бүртгэхдээ энэхүү журмаар тогтоосон бичиг баримтын бүрдэл, бүртгэлийн шалгуур хангасан эсэхийг хянаж, шаардлага хангасан үнэт цаасыг бүртгэнэ. Зөвхөн бүртгэгдсэн үнэт цаасыг “Арилжаалах эрх олгох журам”-ын дагуу олон нийтэд арилжих зөвшөөрөл олгоно.
10. Үнэт цаасыг МХБ-д бүртгэж, арилжих зөвшөөрөл олгосныг тухайн үнэт цаасанд өгч буй баталгаа гэж үзэхгүй бөгөөд үнэт цаасыг худалдан авсны улмаас хөрөнгө оруулагчид учирсан аливаа хохирлыг МХБ хариуцахгүй.
11. МХБ нь чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор үнэт цаас гаргагч, холбогдох бусад этгээдээс шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргуулан авч болох ба тухайн мэдээллийг олон нийтэд мэдээлэхийг үнэт цаас гаргагч болон үнэт цаасны андеррайтерийн байгууллагаас шаардаж болно.
12. Өргөдөл гаргагч нь бүртгүүлэх баримт бичгийг Монгол хэл дээр, үнэт цаасны танилцуулгыг давхар Англи хэл дээр үйлдэнэ. Баримт бичгийн эх хувь нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол албан ёсны Монгол орчуулгын хамт ирүүлнэ.
13. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 13.1. **“Үндсэн зах”** – Үндсэн захын бүртгэлийн журмын шалгуурыг хангаж, үнэт цаас нь олон нийтэд чөлөөтэй арилжих зөвшөөрөл авсан үнэт цаас гаргагчийн зах;
 - 13.2. **“Туслах зах”** – Туслах захын бүртгэлийн журмын шалгуурыг хангаж, үнэт цаас нь мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хүрээнд арилжих зөвшөөрөл авсан үнэт цаас гаргагчийн зах;

- 13.3. **“Бүртгэлийн хороо”** – зохицуулалттай зах зээлд арилжаалагдаж буй үнэт цаас гаргагч компанийн үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг бүртгэлээс хасах, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийн үйл ажиллагааны дүрэм журмыг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах гэх мэт бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулагч хараат бус шийдвэр гаргагч буюу зөвлөх үүргийг гүйцэтгэгч;
- 13.4. **“Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах ”** - Эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэт цаас гаргагчийн зохион байгуулалтын хэлбэр, үнэт цаасны нэр, нэрлэсэн үнэ, тоо ширхэгт орсон өөрчлөлт, туслах захаас үндсэн захруу шилжих зэрэгтэй холбоотой бүртгэлийн үйл ажиллагаа;
- 13.5. **“Гүйцэтгэх захирал”** – Төрийн өмчийн хорооноос томилогдож, МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/-өөс байгуулсан хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж буй этгээд
- 13.6. **“ Үнэт цаас арилжих зөвшөөрөл ”** - Үнэт цаасыг үнэт цаасны арилжаагаар олон нийтэд арилжих тухай МХБ-ийн зөвшөөрөл;
- 13.7. **“нөлөө бүхий хувьцаа эзэмшигч”** гэж тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;
- 13.8. **“тогтмол мэдээлэл хүргэх шаардлагатай этгээд”** гэж компанийн эрх бүхий албан тушаалтан, дотоод мэдээлэл эзэмшигчид болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг хэлнэ. Тогтмол мэдээлэл хүргэх шаардлагатай этгээдтэй холбоотой хийгдсэн үнэт цаасны арилжааны хэлцэл, гүйлгээг олон нийтэд мэдээлснээр хөрөнгө оруулагчдыг тогтмол мэдээлэлтэй байлгахаас гадна зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлнэ.
- 13.9. **“Өрийг хувьцаагаар солих төсөл”** гэж Компанийн тухай хуулийн 25-р зүйлд заасны дагуу хувьцаагаар солих өр, гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэмд оруулах өөрчлөлт зэргийг зааж өгсөн төслийг хэлнэ.
- 13.10. **“Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч”** гэж СЗХ-ноос хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, СЗХ болон МХБ-ийн тогтоосон шалгуурыг хангасан Монгол улсад бүртгэлгүй, гадаад улсын харьяат үнэт цаас гаргагчийг хэлнэ.
- 13.11. **“Давхар бүртгэл” /Dual listing/** гэж үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор компанийн үнэт цаасыг нэгээс илүү биржид бүртгэх явдал юм. Dual listing гэдэгт анхдагч давхар бүртгэл /dual primary listing/ гэсэн санаа агуулагдах ба энэ нь үндсэн бизнестээ тулгуурлан 2 өөр улсад 2 аж ахуйн нэгж бий болгон бүртгүүлэхийг хэлэх ба тус тусын байршиж буй нутаг дэвсгэрийнхээ хууль журмын хүрээнд бүртгэлийн үйл ажиллагаа нь цаашид явагдана.
- 13.12. **“Хоёрдогч бүртгэл” /Cross/Secondary listing /** гэж компани өөрийн хувьцаагаа дотоодын биржээсээ гадна өөр биржүүд дээр бүртгүүлж, хувьцааг улс хооронд чөлөөтэй арилжих нөхцлийг бий болгох үйл явц юм. Хоёрдогч бүртгэлийг ихэвчлэн хадгаламжийн сертификатыг ашиглан гаргах ба биржүүдийн шалгуур уян хатан байдаг. Учир нь аль хэдийн бүртгэлтэй, өөр орны хувьд бүртгэлийн шаардлага хангаж яваа тул энэ нь давуу тал болдог.

Хоёр. БҮРТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

14. Үнэт цаас бүртгүүлэх тухай өргөдлөө МХБ-д үнэт цаас гаргагчийн хууль ёсны төлөөлөгч нь бичгээр гаргана. Үнэт цаас бүртгүүлэхийг хүссэн өргөдөл гаргахдаа дараах бүрдүүлбэрийг хангасан баримт бичгийг Хавсралт 1-ийн дагуу гаргаж, баталгаажуулан ирүүлнэ.
 - 14.1. Үнэт цаас бүртгүүлэх өргөдөл, /Маягт 1/
 - 14.2. Үнэт цаас гаргагчийн болон андеррайтерийн мэдэгдэл ба баталгаа /Маягт 2- Маягт 4/
 - 14.3. СЗХ-ны журмын дагуу бэлтгэгдсэн үнэт цаасны танилцуулга,
 - 14.4. Андеррайтерийн байгууллагын болон бусад шаардлагатай мэргэжлийн байгууллагуудын үнэлэлт, дүгнэлт,
 - 14.5. Журмын 86.1-т заасан өргөдлийн хураамж төлсөн баримт,
 - 14.6. Хавсралт 1-т тусгасан бусад баримт бичгүүд болон шаардлагатай нэмэлт баримт бичгүүд,
15. Баримт бичгийг журамд заасан дарааллын дагуу эмхэтгэн хуудас бүрээр дугаарлаж, хавтаслан, нэгдсэн товъёог хийсэн байх ба баримт бичиг нь албан бичгийн стандартын шаардлагыг хангасан байна.
16. МХБ нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн өргөдөл, энэ журмаар тогтоосон баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор хянан үзээд энэхүү журам болон МХБ-ээс тогтоосон шалгуурыг хангаж буй эсэх талаар Бүртгэлийн хороогоор хэлэлцүүлж, Бүртгэлийн хорооны дүгнэлтийг үндэслэн үнэт цаасыг бүртгэх эсэх тухай үндэслэл бүхий шийдвэрийг МХБ-ийн Гүйцэтгэх захирал гаргана.
17. Хянан шалгах хугацааг өргөдөл гаргагчийн баримт материал нь зохих шаардлагыг хангаж, бүрэн бүрдсэн өдрөөс эхлэн тооцох ба шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, тухайн компанийн удирдлагаас үнэт цаас, үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар тодруулга, нэмэлт баримт бичиг гаргуулан авч болно.
18. Энэ журмын 16-д заасан шийдвэр гаргахад нэмэлт баримт бичиг, аудитын болон үнэлгээний зэрэг бусад хөндлөнгийн байгууллага, мэргэжилтний дүгнэлт гаргуулах шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хүртэл хоногоор сунгаж болно.
19. Үнэт цаас гаргагч нь бүртгэгдсэн өдрөөс хойш 6 сарын дотор үнэт цаасаа олон нийтэд санал болгож арилжаагүй бол түүнийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр бүртгэлээс хасч, хариу мэдэгдэл хүргүүлнэ.
20. МХБ нь дараах тохиолдолд үнэт цаасыг бүртгэхээс татгалзаж болно.

Үүнд:

- 20.1. Өргөдлийг зохих журмын дагуу гаргаагүй,
- 20.2. Үнэт цаас гаргагч, эсхүл түүний гаргасан өргөдөл, хавсарган ирүүлсэн баримт бичиг нь тогтоосон шаардлагыг хангаагүй,
- 20.3. Шаардлагатай мэдээллийг өргөдөлд тусгаагүй, эсхүл дутуу тусгасан,
- 20.4. Худал, төөрөгдүүлсэн, алдаатай, эсхүл хоорондоо зөрүүтэй мэдээлэл тусгасан,
- 20.5. Шаардлагатай нэмэлт мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж ирүүлээгүй болон бүртгэлийн ажиллагааг хойшлуулсан хугацаанд зохих арга хэмжээг аваагүй,

20.6. МХБ-ээс тавьж буй шалгуурыг хангаагүй,

20.7. Бусад

21. Үнэт цаас гаргагч нь бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд бүртгэхээс татгалзах эсвэл шалгуур, шаардлагыг хангах хүртэл бүртгэлийн ажиллагааг 6 сар хүртэл хугацаанд хойшлуулж болно.
22. МХБ нь үнэт цаас нь бүртгэгдсэн үнэт цаас гаргагчтай хавсралт ... загварын дагуу "Үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ" байгуулна. Талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
23. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн саналыг харгалзан хувьцаанд үсгэн болон тоон код, үнэт цаасны нэр олгож бүртгэнэ.
24. Үнэт цаасны код, нэрийг давхардуулж үл болно. Харин үнэт цаас гаргагчийн энгийн болон давуу эрхийн хувьцаа, компанийн гаргасан төрөл бүрийн нөхцөлтэй өрийн хэрэгсэл нь бүртгэлд ижил нэрээр бүртгэгдэх боловч тоон кодоор ялгагдана.

Гурав. БҮРТГЭЛИЙН АРГА ХЭЛБЭР

25. Хувьцааг бүртгүүлэх тохиолдолд бүртгэлийн дараах аргуудыг ашиглаж болно. Үүнд:
 - 25.1. Өөрийн эзэмшлийн хувийг санал болгох / захиалгаар болон худалдахаар/
 - 25.1.1. Үнэт цаас гаргагчийн өмнөөс эсхүл өөрөө эзэмшиж буй хувиа олон нийтэд захиалгаар санал болгоход зайлшгүй андеррайтераар дамжуулна.
 - 25.1.2. Үнэт цаас нь өмнө нь гарчихсан компанийн хувьцаа эзэмшигч болон эзэмшихээр захиалга өгсөн этгээд нь хувьцаагаа олон нийтэд худалдахаар санал болгож болох ба тухайн тохиолдолд андеррайтерийн шаардлага тавихгүй.
 - 25.2. Хаалттай хүрээнд санал болгох /Байршуулах/
 - 25.2.1. Нийтэд худалдах, захиалга авахаас өмнө андеррайтерийн байгууллагад, бусад этгээдэд үнэт цаас гаргагчийн хувьцааг хаалттай хүрээнд нэр заан эзэмшүүлж болно.
 - 25.2.2. Олон нийтэд тухайн үнэт цаас нь эрэлтэй бол МХБ-ийн зүгээс хаалттай хүрээнд санал болгохыг зөвшөөрөхгүй байж болно.
 - 25.3. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй үнэт цаас санал болгох
 - 25.3.1. Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 38 дугаар зүйлд болон 25.6, 34.2 гэх зэрэг холбогдох заалтуудын дагуу одоогийн хувьцаа эзэмшигчдэд хувьцааг тэргүүн ээлжинд давуу эрхтэйгээр санал болгох тохиолдолд андеррайтераар дамжуулна.
 - 25.3.2. Хэрэв тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй гаргаж байгаа үнэт цаасны дүн нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон зах зээлийн үнэлгээг 50 ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлж байвал дараах нөхцлийг хангах шаардлагатай. Үүнд:
 - 25.3.2.1. Андеррайтераар дамжуулсан байх
 - 25.3.2.2. Тэргүүн ээлжинд худалдан авах эрхтэй үнэт цаас гаргах асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэсэн байх,

- 25.3.2.3. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлтгэн, хувьцаа эзэмшигчиддээ мэдээллэх ба уг танилцуулгад хууль тогтоомж, журамд тусгасан мэдээллийг агуулсан байх,
- 25.3.3. Зах зээлийн үнэлгээ нь өндөр томоохон компаниудын хувьд хөрөнгө босгох зорилгоор давуу эрх эдлүүлэх хувьцаа гаргаж байгаа тохиолдолд МХБ нь андеррайтерын шаардлага тавихгүй байж болно. Энэ тохиолдолд компани нь МХБ-д урьдчилан мэдэгдсэн байна.
- 25.3.4. Үнэт цаасыг давуу эрх эдлүүлэх замаар санал болгохдоо андеррайтергүй тохиолдолд захиалгын түвшингийн доод хязгаартай холбоотой хууль, журмаар тогтоосон шаардлагыг хангасан байна.
- 25.4. Нээлттэй хүрээнд санал болгох
- 25.4.1. Нээлттэй хүрээнд санал болгож буй үнэт цаасыг эзэмшиж хувь хэмжээнээс үл хамааран эзэмших боломжтой ба энэ тохиолдолд зайлшгүй андеррайтертай байна.
- 25.5. Хуримтлагдсан ашиг, нэмж төлөгдсөн капитал, ногдол ашиг, нөөц хөрөнгө, өр төлбөр зэргийг хувьцаанд шилжүүлэх замаар хувьцаа санал болгох
- 25.6. Компани болон түүний хувьцааг нэгтгэх, нийлүүлэх, хуваах зэрэг арга замаар хувьцаа санал болгох
- 25.7. Туслах захаас үндсэн захруу шилжих замаар хувьцаа санал болгох
26. Анх удаа эсвэл нэмж бүртгүүлж байгаагаас хамаарч бүрдүүлэх баримт бичиг, шалгуур үзүүлэлт зэргийг хөнгөвчлөх, багасгах боломжтой.
27. Нэмж үнэт цаас бүртгүүлэхэд журмын хавсралт 1-ийн дагуу баримт бичиг бүрдүүлэн ирүүлнэ.

Дөрөв. БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

28. Үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгүүлэхэд болон бүртгэлтэй байх хугацаанд энэ журам болон МХБ-ээс тавигдах шалгуурыг хангаж ажиллана.
29. Шинээр ба нэмж үнэт цаас бүртгүүлэхэд, нэгдэж, нийлэх ба хуваагдах замаар үнэт цаас болон компани бүртгүүлэхэд мөн үүнтэй ижил төстэй байдлаар компани, түүний үнэт цаасыг бүртгүүлэхэд энэ бүлэгт заасан шалгуур, нөхцлийг хангах шаардлагатай.
30. Үнэт цаас гаргагч нь зохих хуулийн дагуу хувьцаат компанийн хувьцааг нийтэд санал болгох замаар биржид бүртгүүлэх тохиолдолд СЗХ-ноос эрх авсан андеррайтерийн байгууллагатай байна.
31. Харин компанийн гаргасан хувьцааг нэгтгэх, хуваах тохиолдолд, урьд нь нийтэд танилцуулсан үнэт цаасны танилцуулгын дагуу хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийг хувьцаанд хөрвүүлэх тохиолдолд, ногдол ашгийг хувьцаагаар олгох замаар нэмэлт гаргаж байгаа хувьцааны тухайд мөн зөвхөн одоогийн эзэмшигчдэд төдийгүй мэргэжлийн хөрөнгө оруулагч цөөн тооны этгээдэд хаалттай хүрээнд санал болгож байгаа тохиолдолд олон нийтэд таницуулах үнэт цаасны танилцуулга бэлтгэхгүй байж болох бөгөөд мөн андеррайтерийн байгууллага оролцохгүй байж болно.

Анх удаа үнэт цаас бүртгүүлэх үеийн шалгуур

Үнэт цаас гаргагчид тавигдах шалгуур

32. Үнэт цаас гаргагч нь харьяат улсынхаа хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан байх ба компанийн дүрэм, үйл ажиллагаа нь хууль тогтоомжтой нийцсэн байна.
33. Үнэт цаас гаргагч нь 3-аас доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулсан байна.
34. Үнэт цаас гаргагч нь өргөдөл гаргахаас өмнөх 3 жилийн санхүүгийн тайланг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-д заасан стандартын дагуу бэлтгэж, хүлээн зөвшөөрөгдсөн /СЗХ-нд бүртгүүлсэн/ хараат бус аудиторроор баталгаажуулан, дүгнэлт гаргуулсан байна. Гадны үнэт цаас гаргагчийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /IFRS/, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдөх зарчим /GAAP/-ын аль нэгээр тайлагнасан байж болно.
35. Бүртгүүлэх компани болон түүний хувьцааны хяналтын багцыг хөрвүүлэн эзэмших этгээд, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх захирлаар ажиллах этгээд нь татварын болон хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, төлбөрийн чадвартай, эрх бүхий албан тушаалтан нь байсан болон байгаа компани нь сайн засаглалтай байх.
36. Компанийн одоогийн гүйцэтгэх удирдлага нь үйл ажиллагаа явуулахад шаардагдах туршлагатай байх ба сүүлийн 3 жилийн дотор компанийн удирдлагын баг, сүүлийн 1 жилд нөлөө бүхий хувь эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороогүй байх шаардлагатай.
37. Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөг байна.
38. Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилах, компаниас авч хэрэгжүүлж буй үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц аливаа компанийн арга хэмжээ /corporate actions/, хувьцаа эзэмшигчид эрхээ хэрэгжүүлэх ажиллагааг өөрөө шууд болон итгэмжлэгдсэн төлөөлөлгчөөр дамжуулан Монгол улсад явуулна.

Үнэт цаасанд тавигдах шалгуур

39. Үнэт цаас нь өргөдөл гаргагчийн харьяат улсын хууль тогтоомж болон дүрэмд заасан шаардлагад нийцсэн байна.
40. Үнэт цаасанд тавигдах шалгуур нь бүртгүүлэхээр өргөдөл гаргаж буй тухайн үнэт цаасанд хамаарах болно.
41. Үнэт цаасны танилцуулга нь зохих хууль, журмын дагуу бэлтгэгдсэн байна.
42. Бүртгүүлэх нийт үнэт цаасны 25-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгоно.
43. Журмын 42-т заасан шалгуурыг Зах зээлийн үнэлгээ, үйл ажиллагаа явуулж буй салбараас хамааран 15 хувь хүртэл бууруулж болно.
44. Бүртгүүлэх үнэт цаас нь аливаа барьцаа батлан даалтанд тавигдаж, битүүмжлэгдээгүй, өмчлөх эрхийг шилжүүлэхэд аливаа хязгаарлалтгүй, чөлөөтэй шилжих, арилжигдах боломжтой байна.
45. Үнэт цаасыг арилжаанд оруулах өдөр тус компанийн зах зээлийн үнэлгээ ба компанийн санхүүгийн үзүүлэлтүүд нь дараах 2 шалгуурын аль нэгийг хангасан байна.

Үүнд:

	<i>1-р шалгуур.</i> Ашгийн шалгуур	<i>2-р шалгуур.</i> Борлуулалтын орлогын шалгуур
<i>Зах зээлийн үнэлгээ</i>	5 тэрбум төгрөгөөс дээш	Зах зээлийн үнэлгээ 50 тэрбум төгрөгөөс дээш

<i>Ашиг</i>	Сүүлийн 3 санхүүгийн жилийн ашгийн нийлбэр нь 500.0 сая төгрөгөөс дээш, сүүлийн нэг жилийн ашиг нь 150 сая төгрөгөөс дээш	-
<i>Борлуулалтын орлого</i>	-	Сүүлийн санхүүгийн жилийн борлуулалтын орлого нь 20 тэрбум төгрөгөөс дээш

46. Үнэт цаасыг бүртгэхэд тухайн нөхцлөөс хамаарч нэмэлт шаарлага, нөхцөл тавьж болохоос гадна онцгой тохиолдолд үндсэн шалгуурыг бууруулах буюу хөнгөлж болно. Энэ тохиолдолд үнэт цаас гаргагч нь шалгуурыг хөнгөлүүлэх болон цаашид хангах боломжтой талаар хангалттай үндэслэлийг өргөдөлд тусгана.

Бүртгэлтэй байх хугацааны шалгуур

47. Үнэт цаас нь МХБ-д бүртгэлтэй байх хугацаанд журмын 36, 37, 38, 42-т заасан шалгуурыг хангаж ажиллах шаардлагатай бөгөөд дараах шаардлагыг хангасан байна.
- 47.1. Дараалсан 30 өдрийн нэгж хувьцааны дундаж ханш нь нэрлэсэн үнээс доош орохгүй байх
- 47.2. Ашгийн шалгуураар бүртгэгдсэн компаниудын хувьд арилжааны дараалсан 30 өдрийн зах зээлийн үнэлгээ нь 1.0 тэрбум төгрөгөөс багагүй ба сүүлийн жилийн ашгийн хэмжээ нь 1.0 сая төгрөгөөс багагүй байх
- 47.3. Борлуулалтын орлогын шалгуураар бүртгэгдсэн компаниудын хувьд арилжааны дараалсан 30 өдрийн зах зээлийн үнэлгээ нь 1.0 тэрбум төгрөгөөс, борлуулалтын орлого нь 500.0 сая төгрөгөөс тус тус багагүй байх
- 47.4. Дараалсан 30 өдрийн хувьцаа эзэмшигчдийн тоо 50-иас доош орохгүй байх

Тав. ТОГТМОЛ БИЕЛҮҮЛЭХ ҮҮРЭГ

Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг

48. Компани, түүний үнэт цаас нь МХБ-д бүртгэлтэй байх хугацаанд үнэт цаас гаргагч нь энэ бүлэгт заасан үүргийг биелүүлэн ажиллана.
49. Үнэт цаас гаргагч нь Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, эрх бүхий этгээдийн батлан гаргасан журам, зааврыг хөрөнгө оруулагч, болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана.
50. Үнэт цаас гаргагч болон үнэт цаас нь Тавдугаар бүлэгт тусгасан шалгуурыг хангаж ажиллана.
51. Санхүүгийн тайлан балансыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн үнэн зөв гаргаж, зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулна.
52. Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ногдол ашиг тараах зэрэг corporate action /компанийн хэрэгжүүлэх ажиллагаа/-тай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдох хууль тогтоомж болон түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, шийдвэрийг баримтлан ажиллана.

53. Энэхүү журамд тусгасан мэдээллийг МХБ-д ирүүлэх, олон нийтэд хүргэх хугацааг журмын хавсалт 3-аар тодорхойлсон.

Мэдээлэл ил тод болгох

- 55 Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигч болоод бусад талуудад мэдээллийг ил тод, үнэн бодитой, шуурхай хүргэх үүднээс компанийн албан ёсны цахим хуудсыг нээн ажиллуулна.
- 56 Хууль дүрэм, журам болон МХБ-ийн “Үнэт цаас гаргагчдын мэдээлэл түгээх заавар”-ын хүрээнд үнэт цаасны арилжаа, үнэ ханш, хэмжээ, явцад нөлөөлөх мэдээ, мэдээлэл мөн компанийн болон удирдлагын үйл ажиллагааны талаар мэдээллийг зохих шаардлагын дагуу хувьцаа эзэмшигчдэд болон МХБ-д хүргэж ажиллана. Үүнд дараах ерөнхий болон журам, зааварт тусгасан бусад мэдээллүүд багтана.

56.1 Жилийн санхүүгийн тайлан

- 56.1.1 Үнэт цаас гаргагч нь аудитаар баталгаажсан жилийн санхүүгийн тайлангаа аудитын дүгнэлтийн хамт тогтоосон хугацаанд МХБ-д ирүүлж, олон нийтэд мэдээлнэ.
- 56.1.2 Жилийн санхүүгийн тайлан нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- 56.1.2.1 Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн гаргасан байх,
- 56.1.2.2 Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, эсхүл өөр ижил төстэй стандартаар аудит хийлгэсэн байх,
- 56.1.3 Үнэт цаас гаргагчийн удирдлага, компанийн засаглалын бүтэц, үүргийн талаар болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг жилийн тайлантай хамт мэдээлнэ.

56.2 Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан

- 56.2.1 Үнэт цаас гаргагч нь хагас жилийн санхүүгийн тайланг стандартын дагуу бэлтгэн гаргаж, МХБ-д тогтоосон хугацаанд ирүүлнэ.
- 56.2.2 Харин улирал тутмын санхүүгийн тайланг сайн дурын үндсэн дээр МХБ-д ирүүлж болохоос гадна олон нийтэд нийтэлж болно.

56.3 Компанийн үйл явдлын хуанли

- 56.3.1 Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгүүлсэн даруй болон бүртгүүлснээс хойш тогтоосон хугацаанд тухайн жилд төлөвлөсөн үйл явдлын хуанли бэлтгэж МХБ-д ирүүлэх ба өөрчлөлт орсон тухай бүрт мэдэгдэнэ.
- 56.3.2 Компанийн үйл явдлын хуанлид хувьцаа эзэмшигчдийн хурлын тов, жилийн болон улирлын санхүүгийн тайлан, бусад мэдээг нийтлэх хугацаа гэх мэт хувьцаа эзэмшигч зайлшгүй чухал үйл явдлын товын талаарх мэдээллийг оруулна.

56.4 Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээлэл

- 56.4.1 Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагаатай холбоотой үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц аливаа мэдээллийг МХБ-д бичгээр болон цахим хэлбэрээр, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ. Үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээлэл гэдэгт зах зээлийн ханшийг огцом өөрчлөх боломжтой мэдээллийг ойлгоно.
- 56.4.2 Үнэт цаас гаргагч нь мэдээллийг үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц үйл явдал болсон даруй буюу дараагийн өдрийн арилжаа эхлэхээс доод тал нь 1 цагийн өмнө мэдэгдэнэ.
- 56.4.3 Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлж, зах зээлийн бүх оролцогчдыг адил тэгш боломжоор хангана.

- 56.4.4 Үнэт цаас гаргагч нь дараах тохиолдлуудад үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээллийг олон нийтэд мэдээлэх ажиллагааг түр хойшлуулж болно. Үүнд:
- 56.4.4.1 Тус мэдээлэл нь үнэт цаас гаргагчийн төлөвлөгөө, шийдвэрээс үүдэлтэй,
 - 56.4.4.2 Мэдээллийг нийтлэх нь үнэт цаас гаргагчийн хууль ёсны эрх ашгийг зөрчихүйц тохиолдолд,
- 56.4.5 Үнэт цаасны үнэ ханштай холбоотой мэдээллийн нууцыг үнэт цаас гаргагч тухайн мэдээллийг олон нийтэд мэдээлэх хүртэл чанд хадгална. Мэдээлэл алдагдсан тохиолдолд, үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөхүйц мэдээллийг нийтэд мэдээлэх журмын дагуу нэн даруй зах зээлд мэдээлнэ.
- 56.5 Компанийн эрх бүхий албан тушаалтан, дотоод мэдээлэл эзэмшигчидтэй холбоотой мэдээлэл**
- 56.5.1 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй хувьцаа болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн хувь хэмжээ, тоо ширхэгт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг үнэт цаас гаргагч нь МХБ-д мэдэгдэнэ.
- 56.5.2 Тогтмол мэдээлэл хүргэх шаардлагатай этгээдүүд нь тухайн үнэт цаас гаргагч компанийн үнэт цаастай холбоотой хийгдсэн аливаа хэлцэл бүрийн мэдээллийг үнэт цаас гаргагчид ажлын 1 хоногт багтаан мэдэгдэнэ.
- 56.5.3 Үнэт цаас гаргагчид хүргэх мэдэгдэлд дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- 56.5.3.1 Тогтмол мэдээлэл хүргэх шаардлагатай этгээдийн нэр, хувь хүн эсвэл хуулийн этгээд аль нь болох,
 - 56.5.3.2 ТУЗ-ийн хараат болон хараат бус гишүүн, гүйцэтгэх удирдлага, хувь эзэмшигч гэх зэрэг албан тушаалын байдал,
 - 56.5.3.3 Хэлцлийн төрөл /Авсан, зарсан талаар/
 - 56.5.3.4 Хэлцэл хийгдсэн хэлбэр /үнэт цаасны арилжаагаар эсвэл бусад хэлбэрээр/,
 - 56.5.3.5 Үнэт цаасны төрөл, тоо хэмжээ,
 - 56.5.3.6 Үнэт цаасны нэр, код,
 - 56.5.3.7 Хэлцлийн нийт үнийн дүн,
 - 56.5.3.8 Хэлцэл хийсэн огноо,
 - 56.5.3.9 Мэдэгдэл хүргүүлсэн огноо,
- 56.5.4 Үнэт цаас гаргагч нь журмын 51.6.2-д заасан мэдээллийг энэ тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэн даруй МХБ-д бичгээр болон цахим хэлбэрээр мэдэгдэх ба 51.6.3.1-ээс бусад мэдээллийг олон нийтэд хүргэнэ.
- 56.5.5 Үнэт цаас гаргагч болон МХБ нь хүлээж авсан мэдээллийг нэгтгэн сан үүсгэж хадгалах ба нийтэлсэн мэдэгдлийг 2 жилийн хугацаанд нийтэд ил тод байлгана.
- 56.6 Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчидтэй холбоотой мэдээлэл**
- 56.6.1 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувь хэмжээнд өөрчлөлт орох тухай бүр нь үнэт цаас гаргагч болон МХБ-д мэдэгдэнэ.
- 56.7 Үнэт цаас гаргагч нь МХБ-д ирүүлсэн болон олон нийтэд түгээсэн мэдээллийн үнэн зөв, бодитой, бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах ба түүнээс үүдэх хариуцлагыг хүлээнэ.

**Зургаа. ГАДААД УЛСАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ**

- 57 СЗХ-ноос хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй, СЗХ болон МХБ-ийн тогтоосон шалгуурыг хангасан гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч нь МХБ-д үнэт цаасаа бүртгүүлэн, арилжихаар өргөдөл гаргаж болно.
- 58 Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч нь хоёрдогч буюу давхар бүртгэлээр МХБ-д бүртгүүлэхдээ үнэт цаасаа шууд бүртгүүлэх эсвэл хадгаламжийн бичиг гаргах боломжтой.
- 59 Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагчийн хувьд МХБ-д бүртгүүлэх ажиллагаа болон бүртгэгдсэнээс хойш хэрэгжүүлэх арга хэмжээ нь дотоодын үнэт цаас гаргагчийн нэг адил ерөнхий нөхцөлтэй байна. Өөрөөр хэлбэр журмын дагуу баримт бичгийг бүрдүүлэн ирүүлэх, журмаар тавигдах шалгуур, нөхцлийг хангах, хураамж төлбөр төлөх, хариуцлага хүлээх заалтууд нэгэн адил үйлчилнэ.
- 60 Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангахад болон дотоодын зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан онцгой тохиолдолд гадаад улсын харьяат үнэт цаас гаргагчдад нэмэлт шалгуур тогтоож болно.
- 61 Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч нь Монгол улсын болон тухайн гадны орны хууль эрхзүйн зөрүүтэй байдлын талаар, түүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдлийн талаар харьцуулсан мэдээллийг үнэт цаасны танилцуулгад тусгаж, олон нийтэд мэдээлнэ.
- 62 Хоёрдогч буюу давхар бүртгэл хийлгэхээр өргөдөл гаргагч нь Монгол улсын мөнгөн тэмдэгтээр хувьцаагаа бүртгүүлэн арилжих ба хэрэв эрх бүхий этгээдээс хүлээн зөвшөөрөгдсөн бол гадаад валютаар үнэт цаасаа гаргаж болно.
- 63 МХБ болон тухайн гадны орны бирж хооронд үнэт цаасны арилжааны болон бусад зохицуулалтын систем байхгүй бол бирж хооронд харилцан тохиролцож, гэрээ байгуулсаны үндсэн дээр хийж болно.
- 64 Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч нь журмын 38-д заасан компанийн арга хэмжээтэй /corporate action/ холбоотой ажиллагааг эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн үнэт цаасны хадгаламжийн болон кастодианы байгууллагаар төлөөлүүлэн гүйцэтгүүлнэ.
- 65 Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч нь давхар бүртгүүлсэн биржүүдэд болон хувьцаа эзэмшигч нарт хүргэх мэдээллийг нэгэн зэрэг түгээх шаардлагатай ба МХБ-д ирүүлэх мэдээллийг Монгол ба Англи хэл дээр бэлтгэн ирүүлнэ.
- 66 Гадаад улсын давхар бүртгэлтэй биржид тухайн үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй холбоотой ямар нэгэн өөрчлөлт орсон, зөрчил дутагдал, хариуцлагын арга хэмжээ авагдсан, бүртгэлээс хасагдсан гэх мэт тохиолдолд үнэт цаас гаргагч нь нэн даруй МХБ-д мэдэгдэнэ.
- 67 Гадаад улсын харьяат үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгэлтэй байх хугацаандаа хувьцаа эзэмшигчид, эрх бүхий байгууллагатай харилцах албан ёсны төлөөлөгчийг томилон Монгол улсад байнгын ажиллуулахыг МХБ-ээс шаардаж болно.

Долоо. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 68 Дараах тохиолдолд үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна. Үүнд:
 - 68.1 Үнэт цаас гаргагч нь хууль, журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдсан;
 - 68.2 Үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хэлбэр өөрчлөх тухай шийдвэр гарсан;
 - 68.3 Эрх бүхий этгээдийн шийдвэрээр бүртгэлтэй үнэт цаасны нэр өөрчлөгдсөн;
 - 68.4 Туслах захаас үндсэн захруу шилжсэн
 - 68.5 Үндсэн захаас туслах захруу шилжсэн

Туслах захаас үндсэн захруу шилжих

- 69 Туслах захад бүртгэлтэй компани нь зохих шаардлагыг хангасан тохиолдолд үндсэн захад шилжих хүсэлтээ биржид гаргаж болох ба уг асуудлыг журмын 16-д заасны дагуу Бүртгэлийн хороогоор хэлэлцүүлж, Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
- 70 Дараах тохиолдолд Туслах захаас Үндсэн захруу шилжих хүсэлтээ гаргаж болно.
- 70.1 Бүртгэлийн журмаар тогтоосон үндсэн захын шалгуурыг бүрэн хангасан,
- 70.2 Хүсэлт гаргахад болон түүнээс 12 сарын өмнөх хугацаанд компани, түүний үнэт цаас нь хууль, журам, заавар зөрчин хянаж, шалгагдаагүй, ял шийтгэл эдлээгүй байх,
- 71 Хүсэлтийг өргөдлийн маягтын дагуу гаргаж, хавсралт 1-т тусгасан барим бичгийн хамт бүрдүүлэн ирүүлнэ.
- 72 Хөрөнгө санхүүжилт босгох зорилгогүйгээр зах хооронд шууд шилжих тохиолдолд андеррайтергүй байж болох ба журамд заасан баримт бичгийн бүрдүүлэлт, үнэт цаасны бүртгэлийн танилцуулгын шаардлага зэргийг хөнгөлж болно.
- 73 Шилжих тухай шийдвэр гарсан даруй буюу ажлын нэг өдөрт багтаан олон нийтэд мэдээлэх буюу МХБ-д мэдэгдэл хүргэх ба нийтэд мэдээлснээс хойш доод тал нь ажлын 5 өдрийн дараа үндсэн захын арилжаанд оролцоно.
- 74 Шилжих тухай нийтэд хүргэх мэдэгдэлд дараах агуулгыг хамруулсан байна.
- 74.1 Шилжүүлэг хийх болсон шалтгаан, үндэслэл тайлбар,
- 74.2 Үндсэн захын шалгуурыг хангасан болохыг батлах баримт,
- 74.3 Шилжих хугацаа буюу үндсэн захад арилжиж эхлэх огноо
- 74.4 Зах тухай бүрийн үнэт цаасны нэр, код,
- 74.5 Биржээс мэдэгдэлд тусгах шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл,
- 75 Үнэт цаас гаргагчийн хувьцаа нь туслах захаас үндсэн захад шилжсэн тохиолдолд туслах захад бүртгэлтэй байсан хөрвөх хувьцаа хэлбэрийн үнэт цаас, түүнтэй төстэй эрхүүд, опцион зэрэг нь шууд үндсэн захад шилжинэ.

Үндсэн захаас туслах захруу шилжих

- 76 Үндсэн захад бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн хүсэлтийг харгалзан дараах тохиолдолд үндсэн захаас туслах захруу шилжүүлэн бүртгэж болно. Уг асуудлыг Үнэт цаасны бүртгэлийн хороогоор хэлэлцүүлж, Гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.
- 76.1 Бүртгэлийн журмаар тогтоосон үндсэн захын шалгуурыг бүрэн хангах боломжгүй болсон ба туслах захын шалгуурыг хангаж байгаа,
- 76.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаар зах хооронд шилжих асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд,
- 76.3 Бусад
- 77 Бүртгэлд өөрчлөлт оруулахад шинээр буюу дахин бүртгэгдэх үнэт цаас нь энэ журмын 39-46-д заасан шалгуурыг хангасан байна.
- 78 Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг Бүртгэлийн хорооны санал, дүгнэлтийг үндэслэн Гүйцэтгэх захирал гаргана.

**Найм. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ,
БҮРТГЭЛЭЭС ХАСАХ**

- 79 Үнэт цаас гаргагч нь өөрийн үнэт цаасыг бүртгэлээс түр түдгэлзүүлэх болон хасуулах тухай хүсэлт гаргаж болох ба энэ тохиолдолд биржээс тавих нөхцөл, шаардлагыг хангасан байна.
- 80 Журмын 74-т заасан хүсэлтэнд дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
- 80.1 Үнэт цаас гаргагчийн нэр,
 - 80.2 Үнэт цаасны талаархи мэдээлэл, /код, тоо хэмжээ, төрөл гэх мэт/
 - 80.3 Хүсэлт гаргах болсон шалтгаан, үндэслэл тайлбар ба нотлох баримт бичиг,
 - 80.4 Бүртгэлээс түр түдгэлзүүлэх болон хасуулах огноо,
 - 80.5 Хэрэв тодорхой нөхцөл, шаардлага тавьж бүртгэлээс түдгэлзүүлэх болон хасуулах бол тэр тухай мэдээлэл,
 - 80.6 Хувьцаа эзэмшигчдэд болон олон нийтэд мэдэгдэл хүргэсэн талаар нотлох баримт,
 - 80.7 Компанийн тухай хуулийн 32 болон 53-р зүйлд заасан нөхцөл бүрдсэн бол тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар, хувьцаа эзэмшигчдээс санал, гомдол гарсан эсэх талаар мэдээлэл, баримт материал,
 - 80.8 Үнэт цаас гаргагчийн уг асуудлыг хариуцан ажиллаж байгаа этгээдийн нэр, харилцах утас, хаяг,
- 81 Үнэт цаас гаргагч нь журмын 74-т заасны дагуу гаргасан хүсэлтээ МХБ-ийн Бүртгэлийн хороо, Гүйцэтгэх захирлын шийдвэр гаргахаас өмнө буцаан авч болно.
- 82 МХБ-ээс биржийн арилжаа, хөрөнгө оруулагчид болон үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг харгалзаж үзсэний үндсэн дээр, үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу үнэт цаасны бүртгэлийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах шийдвэр гаргаж болно.
- 83 МХБ нь өөрийн санаачлагаар болон үнэт цаас гаргагчийн хүсэлтийг харгалзан дараах тохиолдолд үнэт цаасны бүртгэлийг түр түдгэлзүүлж, арилжигдах эрхийг хязгаарлана. Үүнд:
- 83.1 Бүртгэлтэй байх хугацаандаа тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдолд,
 - 83.2 Үнэт цаас нь сүүлийн 1 жилд огт арилжигдаагүй ба үнэт цаасны хөрвөх чадвар алдагдсан,
 - 83.3 Журмын дөрөвдүгээр бүлгийн Бүртгэлтэй байх хугацааны шалгуурыг хангахгүй болсон,
 - 83.4 Давхар бүртгэлтэй биржид тухайн үнэт цаас нь түр буюу бүр мөсөн хасагдсан,
 - 83.5 Бусад
- 84 Үнэт цаасны арилжигдах эрхийг хязгаарлаж, бүртгэлээс түр түдгэлзүүлэх шийдвэрийг МХБ-ийн Бүртгэлийн хорооны дүгнэлт, саналыг үндэслэн гүйцэтгэх захирал гаргана.
- 85 Бүртгэлийг түдгэлзүүлэх болсон нөхцөл, шалтгаан арилсан тохиолдолд үнэт цаас гаргагч нь бүртгэл ба арилжааг сэргээлгэх талаар хүсэлт гаргах ба нотлох баримтыг хангалттай бүрдүүлэн ирүүлнэ.
- 86 МХБ нь хэрэв түтгэлзэх нөхцөл арилсан бол үнэт цаас гаргагч хүсэлт гаргаагүй хэдий ч бүртгэл ба арилжааг сэргээж болно.
- 87 МХБ нь дараах тохиолдолд үнэт цаасыг бүртгэлээс хасна. Үүнд:
- 87.1 СЗХ болон шүүхийн шийдвэрийн дагуу,
 - 87.2 Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар нь алдагдсан, эсхүл үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болсон нь тогтоогдсон, түүнийг татан буулгах ажиллагаа эхэлсэн тохиолдолд СЗХ, шүүх хяналтын байгууллагын шийдвэрийн дагуу,

- 87.3 Тухайн үнэт цаасны хөрвөх чадвар муудсан, биржээс тавьсан шалгуур, шаардлагыг биелүүлж чадахааргүй болсон нь тогтоогдсон,
- 87.4 Үнэт цаасны бүртгэлийг тасралтгүй 6 сараас дээш хугацаанд түдгэлзүүлж, арилжааг хязгаарласан бөгөөд түдгэлзүүлсэн шалтгаан нь арилаагүй,
- 88 Үнэт цаасыг бүртгэлээс хасахад тодорхой нөхцөл, шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч болно.
- 89 МХБ нь үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор мөн зах зээлийн аюулгүй байдал, нэр хүндийг хамгаалахад чиглэсэн үнэт цаасны бүртгэлээс хасах шалгалтыг хийнэ.
- 90 Үнэт цаас гаргагч нь өөрийн хүсэлтээр бүртгэлээс түр түдгэлзүүлэх болон хасуулахаар бол МХБ-д хүсэлт гаргахаас ажлын 20 хоногийн хугацаанаас өмнө хувьцаа эзэмшигчдэд энэ асуудлыг мэдэгдсэн байна.

Ес. ХУРААМЖ

- 91 Үнэт цаас гаргагч нь МХБ-д хувьцаа бүртгүүлэхэд дараах хураамжийг тогтоосон хугацаанд төлнө. Үүнд:
- 91.1 Өргөдлийн хураамж
- 91.2 Элсэлтийн хураамж
- 91.3 Жилийн хураамж
- 92 Хураамжийн хэмжээ, төлөх хугацаа, хөнгөлөлт чөлөөлөлт болон бусад нарийвчилсан асуудлыг Хавсралт 2-т тодорхойлсон болно.
- 93 Бүртгэлийн өргөдлийн хураамжийг үнэт цаас гаргагч нь МХБ-д үнэт цаас бүртгүүлэх болон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлт гаргах бүрт төлнө.
- 94 Элсэлтийн хураамжийг үнэт цаас гаргагчийг МХБ-д бүртгүүлэхэд зөвхөн нэг удаа тус компанийн зах зээлийн үнэлгээнээс хувь тооцон авна.
- 95 Олон нийтэд санал болгон худалдах арга хэлбэр, өдөр зэргээс хамааран элсэлтийн хураамж төлбөр төлөх хугацааг уян хатан тогтоож болно.
- 96 Жилийн хураамжийг үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгэлтэй байх хугацаанд компанийн зах зээлийн үнэлгээнээс хувь тооцон жил бүр төлнө.
- 97 Үнэт цаас гаргагч нь тухайн жилийн бүртгэлтэй байх хоногтоо хувь тэнцүүлэн тооцож жилийн хураамжийг төлж болно.
- 98 Үнэт цаас гаргагч нь нэмж үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд элсэлтийн хураамжийг төлөх ба хураамжийг зөвхөн нэмж бүртгүүлж буй үнэт цаасны зах зээлийн үнэлгээнээс тооцно.
- 99 Ногдол ашгийг үнэт цаасаар олгох, ажиллагсдад үнэт цаас эзэмшүүлэх гэх мэт бодитойгоор нэмж хөрөнгө санхүүжилт татаагүй тохиолдолд нэмж үнэт цаас бүртгүүлэхээр өргөдөл гаргагч компанид хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно.
- 100 Үнэт цаасны бүртгэлийг түдгэлзүүлсэн нь жилийн хураамжийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

Арав. ХАРИУЦЛАГА

- 101 Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллага нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм, журмыг зөрчсөн эсвэл хэрэгжүүлээгүй

(мэдээлэл гаргаж өгөх, олон нийтэд мэдээллэх г.м) тохиолдолд энэ журам болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

- 102 Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг хэрхэн мөрдөж байгаад МХБ-ээс хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар үнэт цаас гаргагчид шаардлага хүргүүлж, журам болон гэрээний дагуу хариуцлага ногдуулж болно.
- 103 Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллагад дараах хэлбэрийн хариуцлагыг хамтад нь эсвэл тус тусад нь тооцно.
 - 103.1 Албан шаардлага тавих,
 - 103.2 Олон нийтэд зөрчил дутагдлын талаар мэдээлэх,
 - 103.3 МХБ-ийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй мөн буруутай үйл ажиллагаа явуулсан тохиолдолд торгууль ногдуулах,
 - 103.4 Үнэт цаасны бүртгэлийг түр түдгэлзүүлэх,
 - 103.5 Үнэт цаасыг бүртгэлээс хасах,
 - 103.6 Цаашид МХБ-д үнэт цаас бүртгүүлэх эрхийг хязгаарлах
- 104 Ногдуулах хариуцлагын хэлбэрийг сонгохдоо, МХБ нь үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтан болон андеррайтерийн байгууллагын гаргасан зөрчлийн ноцтой байдал, түүний хэр буруутайг харгалзаж үзнэ. Торгуулийн хэмжээг тогтоохдоо, торгууль нь буруутай талын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг давхар харгалзаж үзнэ.
- 105 Үнэт цаасны танилцуулга, холбогдох баримт бичгийг бэлтгэхэд оролцсон этгээд өөрийн гүйцэтгэсэн ажилтай холбоотойгоор бусдад учруулсан хохирлыг хариуцна.

Арван нэг. БУСАД АСУУДАЛ

- 106 МХБ-ээс үнэт цаас гаргагчтай холбоотой гаргасан аливаа шийдвэр, урьдчилсан шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд, уг шийдвэр гарснаас хойш ажлын 10 хоногийн дотор үнэт цаас гаргагчаас МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд гомдол мэдүүлж болно.
- 107 МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрөх тохиолдолд, уг шийдвэр гарснаас хойш ажлын 20 хоногийн дотор эрх бүхий дээд байгууллага болон харьяа шүүх хяналтын байгууллагад хандаж болно.
- 108 Энэхүү журам нь 2013 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Хавсралт 1:

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Шинээр хувьцаа бүртгүүлэх

- 1.1 Бүртгүүлэх өргөдөл Маягт 1
- 1.2 Үнэт цаас гаргагчийн болон андеррайтерийн мэдэгдэл Маягт 2 - Маягт 4
- 1.3 Үндсэн шалгуурыг хангах талаар баримт
- 1.4 Хууль, журмын дагуу бэлтгэсэн үнэт цаасны танилцуулга. Танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.3 ба 10.5-д заасан мэдээллийг агуулах ба дараах материалыг мөн ирүүлнэ. Үүнд:
- 1.4.1 Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
- 1.4.2 Санхүүгийн тайлан
- Аудитийн байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлийг тодруулгын хамт аудиторын тайлан, дүгнэлт, аудиторын танилцуулгын хамт / Охин болон салбар, төлөөлөгчийн газартай компанийн хувьд нэгдсэн тайлан, хараат компанийн хувьд толгой компанийн тайланг тус тус ирүүлнэ /
- 1.4.3 Эд хөрөнгийн гэрчилгээ
- 1.4.4 Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ
- 1.4.5 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл
- 1.4.6 Эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийн дүгнэлт
- 1.4.7 Шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтний үнэлэлт, дүгнэлт
- 1.4.8 Андеррайтерийн байгууллагын дүгнэлт, үүрэг амлалт
- Андеррайтерийн хараат бус байдлын талаар,
 - Хэрэв хувьцааг анхдагч зах зээлд андеррайтераар дамжуулахгүй өөрөө худалдах бол мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах маркетингийн төлөвлөгөө, зарласан хувьцаанаас анхдагч зах зээлд гаргах хувьцааны захиалга буюу албан бичиг / нийлүүлэх хувьцааны тоо ширхэг, үнэ, нийлүүлэлт хийх хугацаа/,
- 1.4.9 Үнэт цаасыг санал болгох хэлбэр, арга зам
- Тогтоосон үнээр, захиалгын бүртгэлээр, дуудлага худалдаагаар зэрэг нийтэд санал болгон арилжих арга хэлбэр,
- 1.4.10 Хувьцааны нэрлэсэн үнэ, худалдахаар санал болгосон үнийг тогтоосон үндэслэл, тооцоо, үнийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэр,
- 1.10 Компанийн засаглалын талаарх эрх бүхий этгээдийн дүгнэлт, /Хавсаргах баримт бичиг/
- 1.11 Хувьцааг хаалттай хүрээнд буюу нэр зааж эзэмшүүлэх бол үндэслэл, үнэлгээний байгууллагын болон төлбөр төлсөнийг батлах баримт,
- 1.14 Эрх бүхий албан тушаалтнуудын үүрэг амлалт болон баталгаажуулалт
- 1.15 Үнэт цаас гаргагчаас бусадтай байгуулсан их хэмжээний гэрээ хэлцэл, өр, зээл, барьцаа, баталгаа гаргасан бол түүний талаар баримт
- 1.16 Журмын 71-д заасан өргөдлийн болон элсэлтийн хураамж төлсөн баримт
- 1.17 Биржээс шаардлагатай гэж үзсэн бусад материал

2 Нэмж хувьцаа бүртгүүлэх

- 2.1 Нэмж гаргасан үнэт цаас бүртгүүлэх өргөдөл Маягт 1
- 2.2 Шинээр хувьцаа бүртгүүлэхэд бүрдүүлдэг баримт бичгүүдээс шаардлагатай хэсгийг /Үнэт цаасны танилцуулга, Андеррайтерийн дүгнэлт, мэдэгдлүүд, бусад/
- 2.3 Хувьцаа эзэмшигчид хүлээн зөвшөөрч байгаа талаар
- Хуулийн дагуу хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардахтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар баримт материал,
 - Тэргүүн ээлжинд эзэмшүүлэх эсэх талаар гаргасан шийдвэр, үндэслэл ба тайлбар, авч хэрэгжүүлсэн ажиллагааны хэрэгжилт,
 - Өрийг хувьцаанд хөрвүүлэх замаар нэмэлт хувьцаа бүртгүүлэх тохиолдолд “өрийг хувьцаагаар солих төсөл”-ыг хүлээн зөвшөөрсөн талаар,
- 2.4 Бүртгэлийн журмын Тавдугаар бүлэгт заасан тогтмол биелүүлэх үүргийн хэрэгжилт сайн биелэлттэй байгааг тайлбарласан баримт
- 2.5 Өрийг хувьцаагаар солих тохиолдолд өр үүссэнийг батлах баримт, зээлдэгч, харилцагч нар нь өрийг хувьцаагаар солих ажиллагааг хүлээн зөвшөөрсөн талаар
- 2.6 Журмын 71-д заасан өргөдлийн болон элсэлтийн хураамж төлсөн баримт
- 2.7 Бусад

3 Бүртгэлд өөрчлөлт оруулах, Туслах захаас үндсэн захруу шилжих

- 3.1 Бүртгэлд өөрчлөлт оруулахыг хүссэн хүсэлт, өргөдөл
- 3.2 Өөрчлөлт оруулах болсон шалтгаан, нотлох баримт
- 3.3 Туслах захаас үндсэн захын бүртгэлд шилжихтэй холбогдолтойгоор үнэт цаас гаргагч болон андеррайтерийн мэдэгдэл
- 3.4 Шилжүүлгийн мэдэгдлийн агуулгын үндсэн шаардлага
- 3.5 Туслах захаас үндсэн захын бүртгэлд шилжих шаардлагыг хангасныг нотлох баримт, цаашид МХБ-д мэдээлэх үүрэг, амлалт
- 3.6 Бусад

4 Бүртгэлээс түдгэлзүүлэх, бүртгэлээс хасуулах

Үнэт цаас гаргагч нь өөрийн хүсэлтээр бүртгэлийг түдгэлзүүлэх ба бүртгэлээс хасагдах шийдвэр гаргуулахад дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:

- 4.1 Журмын 62-р зүйлд тусгасан агуулга бүхий үнэт цаас бүртгэлээс хасуулах тухай хүсэлт;
- 4.2 Компанийн эрх бүхий этгээдийн шийдвэр; /Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн холбогдох шийдвэр/
- 4.3 Компанийг өөрчлөн зохион байгуулах бол өөрчлөн зохион байгуулах төсөл / төсөлд компанийг өөрчлөн зохион байгуулах шалтгаан, зорилго, хувьцааг хөрвүүлэх арга, тооцоог тусгасан байна/;
- 4.4 Компанийг өөрчлөн зохион байгуулах асуудлаар эсрэг саналтай байсан буюу хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам, түүнийг баталж, мөрдөх тухай шийдвэр;
- 4.5 Хувьцаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоосон тухай үнэлгээний байгууллагын дүгнэлт;

- 4.6 Компанийг татан буулгаж байгаа бол татан буулгах комисс байгуулсан тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 4.7 Компанийг татан буулгасны дараа нэхэмжлэл гаргах журам, үлдэгдэл эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам;
- 4.8 Өөрчлөн зохион байгуулагдах болон татан буугдах үеийн дуусгалтын тайлан баланс;
- 4.9 Бүртгэлийн хураамжийн өртэй тохиолдолд хураамж төлсөн баримт;
- 4.10 Бусад

Маягт 1

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДЛИЙН МАЯГТ

/Шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлэхэд/

Хэнд: Монголын хөрөнгийн бирж,
Бүртгэлийн алба

Огноо:

Эрхэм танаа,

Бид [Үнэт цаас гаргагч компани, түүнийг төлөөлж] энэхүү маягтын II-д тусгасан үнэт цаасыг Монголын хөрөнгийн бирж /цаашид МХБ гэх/-ийн Бүртгэлийн журмын дагуу бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна.

I. Үнэт цаас гаргагч:

Үнэт цаас гаргагчийн оноосон нэр

Улсын бүртгэлийн гэрчилгээний болон регистрийн дугаар

Үйл ажиллагааны үндсэн /туслах/ чиглэл

Үнэт цаас гаргагч компанийн үүсэн байгуулагдсан огноо /тасралтгүй үйл ажиллагаа явуулсан жил/

Албан ёсны хаяг

Шуудангийн хаяг /цахим/

Холбоо барих утас

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцах этгээдийн нэр, холбоо барих хаяг, утас

Компанийн одоогийн удирдлага /ТУЗ ба гүйцэтгэх захирал/ болон нөлөө бүхий хувь эзэмшигчдийн талаар

Нэр	Эрхэлдэг ажил алба /хуулийн этгээд бол хаяг байршил/	Хувьцаа эзэмшиж буй хэмжээ

Хараат болон охин компани, компанийн нэгдэлд хамааралтай этгээдийн талаархи мэдээлэл

Нэр	Хаяг байршил /үйл ажиллагааны чиглэл/	Холбоо хамаарал

Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг /гүйцэтгэх захирал/-ийн боловсрол мэдлэг, туршлага

II. Бүртгүүлэх үнэт цаас:

Үнэт цаасны нэр

Үнэт цаасны төрөл

Үнэт цаас бүртгүүлэх хэлбэр /үнэт цаас эсвэл хадгаламжийн бичиг/

Хэрэв суурь үнэт цаас нь хадгаламжийн бичгээр төлөөлөгдөж байвал суурь үнэт цаасны талаар

(Бүртгэлтэй бирж, бүртгэгдсэн хэмжээ, үнэ, төрөл гэх мэт мэдээллийг тэмдгэлнэ)

Нийтэд санал болгон худалдах хугацаа

Бүртгүүлэх үнэт цаасны хэмжээ, үнэ, үнийн дүн:

Төрөл	Мөнгөн нэгж	Тоо хэмжээ /А/	Нэрлэсэн үнэ /В/	Нийт дүн /С=А*В/
<i>Олон нийтэд санал болгохоос өмнө</i>				
Энгийн				
Давуу эрхийн				
Дүн				

<i>Олон нийтэд санал болгох /шаардлагатай тохиолдолд дээд, доод хэмжээг тодорхойлж болно/</i>				
Энгийн				
Давуу эрхийн				
Дүн				
<i>Олон нийтэд санал болгосны дараа буюу Бүртгүүлэх үнэт цаасны хэмжээ</i>				
Энгийн				
Давуу эрхийн				
Нийт дүн				

Олон нийтэд санал болгон гаргах үнэт цаас:

а) Үнэт цаасны борлуулалтаас олох хөрөнгө

Төрөл	Мөнгөн нэгж	Тоо хэмжээ /А/	Нэрлэсэн үнэ	Санал болгон худалдах үнэ /В/	Санал болгох нийт үнийн дүн /С=А*В/
Энгийн					
Давуу эрхийн					
Нийт дүн					

б) Борлуулалтаас орж ирэх хөрөнгө түүний зарцуулалт

.....

с) Олон нийтэд санал болгон арилжих арга хэлбэр

.....

Одоогоор МХБ-д үнэт цаас гаргагчийн хувьцаа бүртгэлтэй эсэх

а) Тийм,

Уг өргөдөлд тусгасан бүртгүүлэх үнэт цаас нь өмнөх үнэт цаастай ижил төрөл, нөхцөлтэй эсэх

б) Үгүй,

.....
 (үнэт цаас нь одоохондоо адил биш боловч ирээдүйд адил болох бол хэзээ адил болох мэдээллийг дээрхид тусгана)

Үнэт цаас гаргагч нь өөр хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх

.....
 (Бүртгэлтэй бол хөрөнгийн биржийн талаар болон бүртгэлтэй үнэт цаасны талаар бичнэ)

Сүүлийн 6 сарын байдлаар аль нэг хөрөнгийн биржид үнэт цаас бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эсэх

.....
 (Тайлбарыг бичнэ)

III. Үнэт цаасны андеррайтер болон бусад этгээдийн оролцоо:

Мэргэжлийн андеррайтер байгууллагаар дамжуулсан эсэх

а) Тийм,

Андеррайтерийн талаар мэдээлэл

.....
.....
.....
.....

(Андеррайтер нь маягт „,-ын дагуу мэдэгдэл ба баталгаа гаргана)

b) Үгүй,

.....
(Тайлбар гаргана)

Үнэт цаас бүртгүүлэх ажиллагаанд оролцсон бусад мэргэжлийн байгууллагууд, тухайлбал хуулийн байгууллага, үнэлгээ, аудитын байгууллагууд нь Маягт „,-ын дагуу баталгаа гаргахаас гадна, зохих тайлбарыг хийж болно.

Хөрөнгө оруулалтын компанийн хувьд хэрэв санал болгосон кастодион, удирдлагын компани болон хөрөнгө оруулалтын зөвлөгч байгаа бол тэдгээрийн нэрс

.....

Энэхүү өргөдөл болон хавсаргах баримт материалыг бэлтгэхэд мэдлэг туршлагын зөвлөгөө өгч, гар бие оролцсон дээр дурьдагдаагүй этгээдийн талаархи мэдээлэл

Овог нэр	Эрхэлдэг ажил алба /хуулийн этгээд бол хаяг байршил/	Боловсрол	Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон байдал

1. Захирлын нэрс

(Монгол)

(Англи)

.....
.....
.....

МЭДЭГДЭЛ

Үнэт цаас гаргагчийн мэдэгдлийн агуулга

Үнэт цаас бүртгүүлэхээр товлосон өдрөөс өмнө, үнэт цаас гаргагч нь гарын үсгээр баталгаажуулсан дараах агуулга бүхий мэдэгдлийг гаргана. Үүнд:

- Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр
- Үнэт цаасны танилцуулга, мэдэгдлийг “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн
- Үнэт цаасны танилцуулгыг гаргаснаас хойш үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, санхүүгийн байдал, ашиг алдагдал, бизнесийн хэтийн төлөвт том өөрчлөлт ороогүй
- Үнэт цаас гаргагч нь “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль, дүрэм, журамтай танилцсан бөгөөд үнэт цаас гаргагчийн үнэт цаас нь бүртгэлтэй хэвээр байх эсэх нь одоо болон ирээдүйд хүчин төгөлдөр мөрдөгдөх хууль дүрэм журмыг мөрдөхөөс хамааралтай болохыг хүлээн зөвшөөрч, Үнэт цаасны бүртгэлийн хураамжаа төлөхийг баталгаажуулсан мэдэгдэл гаргана.

Маягт 2

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Огноо.....

Үнэт цаас гаргагч компанийн мэдэгдэл:

Үнэт цаас гаргагч[компанийн нэр, удирдлагын нэр] бид өөрсдийн мэдлэг чадвараа бүрэн ашиглан дараах ажиллагааг хийж гүйцэтгэсэн гэдгээ мэдэгдэж байна.

1. МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үнэт цаасыг гаргаж бүртгүүлэх, нийтэд санал болгох, танилцуулахтай холбоотой шаардагдах бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн.
2. Үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д тусгагдсан үнэт цаас гаргагч болон үнэт цаасны нөхцөл шалгуурыг бүрэн хангасан.

3. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д заасан болон хууль, тогтоомжоор шаардах бусад мэдээллийг бүртгэлийн баримт бичигт тусгасан. Хэрэв сүүлчийн хувилбар хүргэгдээгүй бөгөөд мэдээлэл дутуу бол дутуу мэдээллийг тусгаж, залруулан хүргүүлнэ.
4. Үнэт цаас бүртгүүлэх зөвшөөрөл авахтай холбоотойгоор үнэт цаас гаргагчийн өргөдөлд тусгасан мэдээлэлтэй зөрчилдөх ямар нэгэн баримт материал байхгүй болон. Хэрэв зөрчилдөх материал байх тохиолдолд МХБ-д ил болгож, мэдээлнэ.

Түүнчлэн үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгэлтэй байх хугацаанд дараах үйл ажиллагааг тогтмол авч хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Бидний үнэт цаас МХБ-ийн Үндсэн захад бүртгэгдсэн нөхцөлд МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох журам, заавраар тогтоосон шалгуурыг хангаж ажиллах ба цаашид зохих дүрэм, журмыг баримталж ажиллана.
2. Өргөдлийг хүлээн авч, үнэт цаасыг бүртгэх тухай шийдвэр гарсан тохиолдолд “Арилжаалах эрх олгох журам”-ын дагуу арилжааг эхлүүлэх хүсэлтээ зохих баримт материалын хамт МХБ-д хүргүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захиралын мэдэгдэл:

Би[үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал] өөрийн эрх мэдлийн хүрэнд Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын шаардлагыг бүрэн дагаж, биелүүлэн ажиллана.

Үнэт цаас гаргагчийн захирлын эрх мэдлийн хүрээнд Монгол улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль, тогтоомж болон МХБ, СЗХ-ны холбогдох журам, зааврын хүрээнд өөрийн мэдлэг чадвараа дайчлан ажиллана.

Дараах зүйлсийг МХБ-ийн журамд заасан тогтоосон хугацаанд цаг алдалгүй хүргүүлнэ. Үүнд:

1. МХБ-ийн зүгээс хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор болон зах зээлийн үйл ажиллагааг хэвийн хангах зорилгоор шаардсан мэдээлэл баримтыг ирүүлэх,
2. МХБ-ийн зүгээс “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг хангаж байгааг шалгах зорилгоор нэхэмжилсэн тайлбар материал, мэдээллийг ирүүлэх,
3. МХБ-ийн Бүртгэлийн албанаас шаардсан баримт материалыг эх хувиар нь болон хуулбарласан хувийг бэлтгэх хүргүүлж, хамтран ажиллах
4. Мөн өөрт шууд холбогдох асуудалд хариу тайлбар гаргаж өгөх,

Би 3 жилийн хугацаанд үнэт цаас гаргагчийн захирлаар ажиллах бөгөөд миний холбогдох хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Бүртгэлийн албанд нэн даруй мэдэгдэнэ. Хэрэв би өөрийн өөрчлөгдсөн хаягаа мэдээлээгүй болон бусад материалд хариу өгөөгүй тохиолдолд хариуцлагыг хүлээн авна гэдгээ ухамсарлаж байна.

Үнэт цаас бүртгүүлэхээр хүргүүлж буй өргөдөл, түүний хавсралт материалд /үнэт цаасны танилцуулга хамаарна/орсон өөрийн тухай мэдээлэл нь бүгд үнэн зөв гэдгийг баталгаажуулахаас гадна хэрэв буруу ташаа мэдээлэл орсон нь нотлогдвол хариуцлага хүлээхээ илэрхийлж байна.

Журмын 35 ба 36-р заалтанд тодорхойлсон эрх бүхий албан тушаалтаны шалгуур, нөхцөлийг хангаж байгааг мэдэгдэж байна.

Бүртгэлийн төлбөр хураамжтай холбоотой мэдэгдэл:

Бүртгүүлэхэд төлөх хураамжийн эхний төлбөр болох өргөдлийн хураамж төгрөгийг дугаартай чекээр банкны дансанд урьдчилж төлсөн.

Үнэт цаас нь МХБ-д бүртгэгдсэн тохиолдолд олон нийтэд санал болгон худалдах нэгж хувьцааны үнэ тодорхой болох ба тухайн өдөрт журмаар тогтоосон хувь хэмжээгээр элсэлтийн хураамжийг МХБ-д төлөхөө мэдэгдэж байна.

Хэрэв үнэт цаас гаргагчийн өргөдөл нь МХБ-ээс зөвшөөрөгдөөгүй, цуцлагдсан буюу үнэт цаас нь бүртгэгдээгүй тохиолдолд үнэт цаас гаргагчийн төлсөн өргөдлийн хураамж нь буцаан олгогдохгүй ба Бирж хураан авах эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Үнэт цаас гаргагчийн нэр

Баталгаажуулсан этгээдийн албан тушаал, овог нэр,
регистрийн дугаар /гарын үсэг/

Баталгаажуулсан этгээдийн албан тушаал, овог нэр,
регистрийн дугаар /гарын үсэг/

Маягт 3

АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

Хэнд: Монголын хөрөнгийн бирж,
Бүртгэлийн алба

Огноо:

Бид [Андеррайтерийн байгууллагын нэр] байршилтай, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 30-д заасны дагуу компанийн үнэт цаасыг олон нийтэд санал болгоход андеррайтерийн үүрэг гүйцэтгэх бөгөөд журамд заасны дагуу дараах мэдэгдлийг гаргаж байна. Үүнд:

1. Компанийн үнэт цаас бүртгүүлэх өргөдлийн маягт болон “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дагуу шаардлагатай бүхий л материалыг МХБ-д хүргүүлсэн.
2. Бид хуульд заасан хэм хэмжээний хүрээнд өөрсдийн хүчин чадлаа дайчлан бодитой лавлагааг хийж, судалсаны үр дүнд доорхи зүйлсийг баталгаажуулсанаа мэдэгдэж байна. Үүнд:

- 2.1.1. Андеррайтер нь Монгол улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм журмын бүхий л нөхцлийг мөрдөж ажилласан ба хүргүүлсэн материалд шаардлагатай мэдээллүүдийг бүрэн агуулсан, материал орхигдуулаагүй болно.
- 2.1.2. Үнэт цаасны танилцуулга болон үнэт цаас бүртгүүлэх өргөдөлтэй хамт хүргүүлж буй андеррайтерийн дүгнэлтийг үнэн зөв, бодитой, бүрэн хийгдсэн гэж үзэж байна.
- 2.1.3. Андеррайтер нь үнэт цаас гаргагч компани болон түүний хувь эзэмшигчидтэй холбоо хамааралгүй бөгөөд бие даасан хөндлөнгийн дүгнэлт гаргасан.
- 2.1.4. Бид андеррайтерийн дүгнэлт гаргах, үнэт цаасны танилцуулга бэлтгэх зэрэг ажиллагаанд шаардагдах мэргэшсэн, туршлагатай, холбогдох саналаа илэрхийлэх хангалттай нөөц бололцоотой гэж үзэж байна.
- 2.1.5. Үнэт цаас гаргагч компанийн удирдлагууд нь компанийн бизнесийн үйл ажиллагааг дангаар болон биеэ даан ажиллах туршлага, мэдлэг, чадвартай мөн бүртгэлтэй компани болсноор хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарласан.
- 2.1.6. Бүртгүүлэхээс өмнөх болон бүртгүүлсэний дараах үнэт цаас гаргагчийн дагаж мөрдөх дүрэм журам, удирдлагын үүрэг хариуцлагатай холбоотой дотоод дүрэм журмыг бий болгосон.

Гарын үсэг

Нэр

Огноо

Маягт 4

АНДЕРРАЙТЕРИЙН БАТАЛГАА

Хэрэв үнэт цаас гаргагч нь анх удаа үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргаж байгаа бол дараах андеррайтерийн баталгаа зайлиггүй шаардлагатай.

Бид [Андеррайтерийн байгууллагын нэр] байршилтай, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 30-д заасны дагуу компанийн үнэт цаас гаргах үйл явцад андеррайтерийн үүрэг гүйцэтгэнэ.

Бид хуулиар тогтоосон хэм хэмжээгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үнэт цаас гаргагч, бусад мэргэжлийн этгээдээс гаргаж өгсөн материалд тулгуурлан үнэт цаасны таницуулга бэлтгэсэн. Уг танилцуулгад тусгасан мэдээлэл болон үнэт цаас бүртгүүлэх өргөдлийн хамт хүргүүлж буй баримт бичгийг нягталж, судалж үзсэний дүнд үнэн зөв гэдгийг баталгаажуулж байна.

Баталгаажуулсан огноо

Гарын үсэг

Тэмдэг

.....

Хавсралт 2:

ХУРААМЖ

1. Хураамжийн төрөл

- 1.1. Өргөдлийн хураамж
- 1.2. Элсэлтийн хураамж
- 1.3. Жилийн хураамж

2. Хураамжийн хэмжээ

- 2.1. Өргөдлийн хураамж: Үнэт цаас гаргагч нь МХБ-д үнэт цаас бүртгүүлэх өргөдөл гаргах тухай бүрт өргөдлийн хураамж болох 3,000,000 /гурван сая/ төгрөгийг буцаан олгогдохгүй нөхцөлтэйгээр төлнө.
- 2.2. Элсэлтийн хураамж: Үнэт цаасны элсэлтийн хураамжийг үнэт цаас гаргагчийг МХБ-д бүртгэхэд зөвхөн нэг удаа тус компанийн зах зээлийн үнэлгээний 0.1 хувиар тооцон авна. Нийтэд санал болгох үнээр зах зээлийн үнэлгээг тооцох ба элсэлтийн

хураамжийн доод хэмжээ нь 12,000,000 /арван хоёр сая/ төгрөг ба дээд хэмжээ нь 240,000,000 /хоёр зуун дөчин сая/ төгрөг байна.

- 2.3. Жилийн хураамж: Бүртгэлтэй компанийн жилийн хураамжийг үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээний 0.005%-иар тооцоон жил бүр авна. Өнгөрсөн оны хамгийн сүүлийн арилжааны өдрийн хаалтын ханшаар зах зээлийн үнэлгээг тооцох ба жилийн хураамжийн доод хязгаар нь 1,200,000 /нэг сая хоёр зуун мянга/ төгрөг ба дээд хязгаар нь 24,000,000 /хорин дөрвөн сая/ төгрөг байна.

3. Хураамж төлөх хугацаа

- 3.1. Өргөдлийн хураамж: Биржид бүртгүүлэх өргөдөл гаргахдаа төлнө.
- 3.2. Элсэлтийн хураамж: Олон нийтэд санал болгох үнэ нь тогтмол бол элсэлтийн хураамжийг МХБ-д үнэт цаас бүртгэх тухай шийдвэр гарсанаас хойш 5 хоногийн дотор, харин санал болгох үнийг захиалгын бүртгэлийн арга болон бусад байдлаар тодорхойлох бол зах зээлд санал болгох үнэ тогтсон тухайн өдрөөс хойш 3 хоногт багтаан төлнө.
- 3.3. Жилийн хураамж: Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй компанийн жилийн хураамжийг тухайн жилийн эхний улиралд багтаан төлнө. Хэрэв “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 92-т заасны дагуу жилийн хураамж төлөх бол

4. Хураамжийн хөнгөлөлт чөлөөлөлт

- 4.1. Үнэт цаас гаргагч нь шинээр болон нэмж үнэт цаас бүртгүүлсэн өдрөөс хойшхи тухайн оны жилийн хураамжаас чөлөөгдөнө.
- 4.2. Бүртгэлээс хасагдах тохиолдолд дээрхтэй адилаар чөлөөлөлт эдэлнэ.
- 4.3. Дараах тохиолдолд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр элсэлтийн хураамжийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж болно. Үүнд:
 - 4.3.1. Үнэт цаас гаргагч нь Үндсэн захад нэмж үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд мөн Туслах захаас үндсэн захад шилжих тохиолдолд
 - 4.3.2. Ногдол ашгийг үнэт цаасаар олгох, ажиллагсдад үнэт цаас эзэмшүүлэх гэх мэт бодитойгоор нэмж хөрөнгө санхүүжилт татахгүйгээр нэмж үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд
 - 4.3.3. Улсын эдийн засагт жинтэй хувь нэмэр оруулах стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн өмчит компанийн үнэт цаасыг бүртгүүлэх тохиолдолд

5. Хариуцлага

- 5.1. Үнэт цаас гаргагч нь журам болон түүний хавсралтаар тогтоосон хувь хэмжээ, хугацаанд зохих хураамжийг төлөөгүй тохиолдолд тухайн үед мөрдөгдөж байгаа Монголбанкны банк хоорондын захын 3 сарын хүүгийн хувь дээр 2%-ийг нэмэгдүүлсэн жилийн хүүгийн алдангийг нэмж төлнө.
- 5.2. Хэрэв төлөх үүрэгтэй хураамж болон бусад аливаа төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хууль дүрэм, журмын дагуу шат дараалсан арга хэмжээг авч, хариуцлага ногдуулна.
- 5.3. Энэхүү журам болон үүнтэй холбогдуулан МХБ-д төлөх ёстой төлбөр, хураамжинд нэмүү өртгийн албан татвар болон бусад татвар, хураамж нэмэгдээгүй болно. Үнэт цаас гаргагчаас төлөх төлбөр, хураамжаас суутгал, шимтгэл авахыг холбогдох хуулиар заагаагүй тохиолдолд, аливаа суутгал, шимтгэл авахгүй.

Хавсралт 3:

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ ЗААВАР

1. Энэ заавар нь үнэт цаас гаргагчийн “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын Тавдугаар бүлгийн 5.2-т заасан мэдээллийг ил тод болгох үүргийн биелэлтийг хангахад чиглэсэн мэдээллийг түгээхтэй холбоотой зохицуулалтыг агуулна.
2. Мэдээний төрөл, мэдээлэх хугацаа, арга зам, шаардлага болон маягтыг хавсралтаар гаргасан ба тогтоосон хугацаанд мэдээлэх үүргийг үнэт цаас гаргагч хүлээнэ.
3. Үнэт цаас гаргагчид мэдээлэх үүргээ биелүүлэх ажиллагааг хялбаршуулах, хөнгөвчлөх, стандартчлах зорилгоор МХБ нь маягт, зааварчилгаа, электрон мэдээллийн платформ буюу системийг бий болгож болно.
4. МХБ нь үнэт цаас гаргагчаас ирүүлэх мэдээлэлд ямар нэгэн өөрчлөлт хийхгүй бөгөөд үнэт цаас гаргагч нь гаргаж буй мэдээлэлд бүрэн хариуцлага хүлээнэ.

Тогтмол мэдээллэх үүрэгтэй мэдээллийн жагсаалт

	Мэдээний төрөл	Мэдээлэх хугацаа	Мэдээнд агуулах зүйлс	МХБ-д ирүүлэх арга зам	Тайлбар
1	Ерөнхий мэдээлэл				
1.1	Нэрийн өөрчлөлт (Компаний нэрийн өөрчлөлт)	Улсын бүртгэлд өөрчлөлт хийлгэснээс хойш ажлын 3 өдрийн дотор	- Хуучин нэр/шинэ нэр; - Шинэ вэб хуудас - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар - Дүрмийн хуулбар - Өөрчлөх тухай шийдвэр	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	Гадны үнэт цаас гаргагчдын хувьд : Хэрвэ дүрэмд өөрчлөлт оруулаагүй бол нэрийн хариуцсан этгээдээр сертификатыг авсан нотариатаар баталгаажуулан ирүүлсэн ба
1.2	Бүртгэгдсэн үндсэн хаяг өөрчлөгдөх	Улсын бүртгэлд өөрчлөлт хийлгэснээс хойш ажлын 3 өдрийн дотор	- Нэр (Компанийн нэр), хаяг, шуудангийн хаяг - Утасны дугаар, факсын дугаар - И-майл хаяг Бичиг баримтын хавсралт; - Компанийн дүрмийн хуулбар	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	Бүртгэгдсэн оффис нь өөр улсад байдаг ү гаргагчийн хувьд: хэрвээ төв буюу үндсэн хаяг нь өөрчлөгдсөн бол эсвэл тухайн менежмент байдаг газар нь өөрчлөгдсөн бол компанийн дүрэмд өөрчлөлт оруулаагүй өөрчлөлтийг хариуцсан этгээдээр сертификат даруйд нь нотариатаар баталгаажуулан ир
1.3	Хуулийн болон түүнтэй холбоотой бичиг баримт хүлээн авах хаяг өөрчлөгдөх	Тухайн өөрчлөлт орсон даруйд мэдэгдэнэ	- Нэр (компанийн нэр), хаяг, шуудангийн хаяг - Утасны дугаар, факсын дугаар - И-майл хаяг	Цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	Хаяг өөрчлөгдсөн нь батлагдсан даруйд л гаргагч нь хууль журам болон түүнтэй хо мэдээлэл хүлээн авдаг шинэ хаягаа мэдэг шаардлагатай.
1.4	Төлбөрийн баримт хүргүүлэх хаяг өөрчлөгдөх	Тухайн өөрчлөлт орсон даруйд мэдэгдэнэ	Шуудангийн хаяг	Цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
1.5	ТУЗ-ийн бүрэлдэхүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга өөрчлөгдөх	Өөрчлөгдсөнөөс хойш ажлын 3 өдрийн дотор	- Овог нэр - Албан тушаал /Хараат бус гишүүн эсэх/ - Оршин суугаа улс, хаяг - Өөрчлөгдөх болсон шалтгаан (хэзээ өөрчлөгдсөн ямар асуудлыг шийдэж чадаагүй, ямар санал зөрүүтэй байсан гэх зэрэг мэдээллийг цаг хугацааны дарааллаар мэдэгдэнэ) Бичиг баримтын хавсралт; Өөрчлөгдсөн тухай бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	Бүртгэгдсэн оффис нь өөр улсад байдаг ү гаргагчийн хувьд: Хэрвээ тохирох хууль, өөрчлөлт оруулаагүй бол шинээр томил сертификат авсан даруйд нь нотариатаар баталгаажуулан ирүүлсэн байна

1.6	Дараах эрх бүхий албан тушаалтнуудын бүтцэд гарсан өөрчлөлт болон үнэт цаас эзэмшлийн мэдээлэл өөрчлөгдөхөд: - Захирал - Гүйцэтгэх захирал - Санхүү хариуцсан захирал - Хөрөнгө оруулагч хариуцсан дарга - Мэдээлэл хариуцсан дарга - Үнэт цаас хариуцсан ажилтан	Ажлын 1 өдрийн дотор	- Нэр, овог, хаяг - Шууд холбогдох утас, факс - Шууд холбогдох и-майл хаяг - Тухайн мэдээллийг хариуцсан этгээдийн И-майл хаяг - Олон нийтэд мэдээлэх үүрэг хариуцсан этгээдүүдийн гар утасны дугаар - Хувьцаа болон үүсмэл санхүүгийн хэрэгсэл эзэмшлийн талаар	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-56-р зүйл
1.7	Дараах интернет холбоосууд өөрчлөгдөхөд: - Үнэт цаас гаргагчийн ерөнхий веб хуудас - И-майл -Албан ёсны холбоо барих утас	Тухайн өөрчлөлт орсон даруйд мэдэгдэнэ	Интернет холбоос	Цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
1.8	Бизнесийн үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөхөд	Тухайн өөрчлөлт орсон даруйд мэдэгдэнэ	Үйл ажиллагааны тодорхойлолт	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
1.9	Санхүүгийн тайлан: Жилийн болон хагас жилийн тайлан	Дараах хугацаанд мэдээллүүдийг илгээсэн байна: Жилийн тайланг дараа жилийн 02-р сарын 10-ний дотор, Хагас жилийн тайланг дараа сарын 20-ны дотор		Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	Жилийн эцсийн тайланг аудитын дүгнэлт ирүүлэх шаардлагатай
2	Хувьцаа эзэмшигчдийн хурал				
2.1	Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл	Шийдвэр гарсанаас хойш ажлын 1 өдрийн дотор	-Хурал хуралдах өдөр, бүртгэлийн өдөр, олон нийтэд мэдээллэх өдөр -Хуралдах газрын хаяг -Хурлаар хэлэлцэх асуудал -Шийдвэр гаргасан этгээд -Шийдвэр гаргасан огноо -Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	

			-Холбоо барих утас		
2.2	Хувь нийлүүлэгчдийн хурлаас гарсан шийдвэр	Ажлын 3 өдрийн дотор /хуралдснаас хойш/	ХЭХ-аас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад материал	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-20.1.8 ҮЦЗЗТХ-56.2.3
3	Ногдол ашиг				
3.1	Ногдол ашиг хувиарлах эсэх тухай шийдвэр	ТУЗ /байхгүй бол ХЭХ/-ийн ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гарсанаас хойш ажлын 3 өдрийн дотор	-Хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ -Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр -Ногдол ашиг төлөх өдөр	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	Компанийн тухай хууль - 46.5
3.2	Ногдол ашгийн тайлан	Ногдол ашиг хувиарлаж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор	-Ногдол ашиг тараасан байдал, тараасан баримт -Ногдол ашиг авсан эзэмшигчдийн жагсаалт - Нийт ногдол ашиг тараалтын дүн	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
4	Компанийн үйл явцын хуанли /календарь/				
4.1	Компанийн үйл явцын хуанли /календарь/	Тухайн жилийн хуанлийг 1-р сарын 15-ны өдрийн дотор, Шинээр бүртгэгдсэн компанийн хувьд уг жилийг дуусах хүртэлх үйл явдалын хуанлийг бүртгэгдсэнээс хойш ажлын 15 өдрийн дотор	- Хийгдэх ажлын төлөвлөлт - Хугацаа - Зохион байгуулах хэлбэр	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
5	Хөрөнгийн бүтэц				
5.1	Их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаар	Шийдвэр гарсанаас хойш ажлын 3 өдрийн дотор	-Үнийн дүн -Хэлцэл хийхээс өмнөх сүүлийн балансын нийт активын дүн -Үнийн дүнгийн нийт активт эзлэх хувь	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
5.2	Компанийн нийт гаргасан хувьцааны 5-с дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл /Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд өөрчлөлт ороход/	Ажлын 1 өдрийн дотор	-Овог, нэр -Эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг -Нийт хувьцаанд эзлэх хувь -Ажлын газар, албан тушаал	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-56-р зүйл
5.3	Бусад барьцаа баталгаа гаргасан тухай мэдээлэлд өөрчлөлт орсон	Ажлын 3 өдрийн дотор	-Зээлдэгч -Зээлдүүлэгч -Зээлийн дүн	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	

			<ul style="list-style-type: none"> -Барьцаат хөрөнгийн гэрчилгээний дугаар -Барьцаа хөрөнгийн нэр -Барьцаа хөрөнгийн байршил -Компанийн өөрийн хөрөнгийн дүн -Өөрийн хөрөнгөнд барьцаа хөрөнгийн үнийн дүнгийн эзлэх хувь -Барьцааны хугацаа -Шийдвэр гаргасан этгээд -Шийдвэр гаргасан огноо 		
5.4	Томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын мэдээлэл өөрчлөлт орсон	Ажлын 3 өдрийн дотор	<ul style="list-style-type: none"> -Харилцагчийн нэр -Харилцагчийн хаяг -Том харилцагч гэж тооцсон үндэслэл -Ямар харилцаатай /бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч, томоохон зээлдүүлэгч/ -Худалдан авалт хийсэн бол сүүлийн 3 жилд нийт худалдан авалтын үнийн дүнд эзлэх хувь -Бэлтгэн нийлүүлсэн бол сүүлийн 3 жилд нийт борлуулалтын үнийн дүнд эзлэх хувь -Томоохон зээл авсан бол сүүлийн 3 жилд нийт өрийн дүнд эзлэх хувь 	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	
5.5	Үнэт цаас гаргагч болон түүний охин, хараат, зэргэлдээ компанид зохион байгуулалтын өөрчлөлт орсон	Ажлын 1 өдрийн дотор	<ul style="list-style-type: none"> -Ямар өөрчлөлт гарсан тухай -Өөрчлөлт гарсан шийдвэр, тогтоолын баталгаажуулсан хуулбар 	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-56-р зүйл
5.6	Үнэт цаас гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан	Ажлын 1 өдрийн дотор	<ul style="list-style-type: none"> -Ямар байгууллага хураасан, битүүмжилсэн -Ямар шалтгаанаар хураасан, битүүмжилсэн -Хөрөнгийг хурааж, битүүмжилсэн байгууллагын шийдвэр, тогтоолын баталгаажуулсан хуулбар 	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-56-р зүйл
6	Бусад				
6.1	Үнэт цаас гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, эсхүл түүнийг түтгэлзүүлсэн, хүчингүй болгосон	Ажлын 1 өдрийн дотор	<ul style="list-style-type: none"> -Ямар төрлийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон -Ямар шалтгаанаар тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлсэн, хүчингүй болгосон 	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-56-р зүйл

			-Тусгай зөвшөөрлийн тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, тогтоолын баталгаажуулсан хуулбар		
6.2	Үнэт цаасны үнэ, ханшид нөлөөлж болох бусад мэдээлэл	Ажлын 1 өдрийн дотор	-Шийдвэр, тогтоолын баталгаажуулсан хуулбар	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/	ҮЦЗЗТХ-56-р зүйл
6.3	Ханшийн хэлбэлзэл үүссэн үед хийх мэдэгдэл	Ажлын 3 өдрийн дотор	-Ханшийн хэлбэл нь компаниас шалтгаалсан эсэх -Шалтгаалсан бол тайлбар, шалгаалаагүй бол тэр талаар мэдэгдэл	Албан бичгээр болон цахим хэлбэрээр /Listing@mse.mn/ Мөн олон нийтэд	

